

Бангкок - Паттая

8 ХОНОГ

Хугацаа:
8 хоног

Маршрут

Газар болон нислэг

Улаанбаатар-Замын үүд-Эрээн хот-Бээжин-Бангкок-Паттаяа-Бангкок-Бээжин-Эрээн хот-Замын үүд-Улаанбаатар

9 хоног

Нислэг

Улаанбаатар-Бээжин-Бангкок-Паттаяа-Бангкок-Бээжин-Улаанбаатар

8 Хоног

Улаанбаатар-Бээжин-Бангкок-Паттаяа

- УБТЗ-д цуглан бүртгэл хийлгэн
Улаанбаатараас – Замын үүд- Эрээн хот-
Бээжин гэсэн маршрутаар Бээжинд хүрнэ
- Бээжинд буугаад Бээжин-Бангкок хотын
нислэгт суун Паттаяа хотод очин буудалдаа
байршина



ӨДӨР 2

Паттаяа - Nong Nooch цэцэрлэг

Өглөөний цайны дараа Тайландын байгаль, зэрлэг ан амьтад, соёлыг хослуулсан алдарт Nong Nooch Цэцэрлэгт хүрээлэнгээр аялна. Nong Nooch-д та амар тайван цэцэрлэг, амьтны хүрээлэн Тайланд соёлыг харуулах амьд тоглолтуудтай танилцаарай

Хөтөлбөрт багтсан: Цэцэрлэгт нэвтрэх тасалбар, Өдрийн хоол, Урлагийн тоглолтын тасалбар

Хөтөлбөрт багтаагүй: Заан унах, Тiр буюу гарын мөнгө



Чөлөөт өдөр /Паттаяа/

- Өглөөний цайгаа буудалдаа ууна. Энэ өдрийг та өөрийн хүслээр чөлөөтэй өнгөрүүлж, аяллын хөтөчөөс очиж болох газрын талаар зөвлөгөө аван дэлгүүр хэсч, далайн эргээр амарч өөрийн хүслээр өнгөрүүлээрэй




Өглөөний цайны дараа Паттая хотын хамгийн их хүмүүс зочилдог зорилтот газруудаар аялах болно. Big Buddha, Паттая хотыг гайхалтай өнцгөөс харж, Bali Hai Pier, Laser Buddha болон Gems Gallery үнэт эдлэлийн дэлгүүр орсны дараа байгууллагаас үнэгүй урамшуулал болгож буй Тай массаж хийлгэж, Паттая хотын бэлэг тэмдэг болсон Walking Street болон Паттая хотын хөвөгч захаар завиар аялан худалдан авалт хийнэ.



Шүрэн арлын аялал

Буудалдаа өглөөний цайгаа уун Coral арал буюу Шүрэн аралруу хурдны завиар аялна. Үзэсгэлэнт Шүрэн арлын гоо зүйг бишрэнгээ Тай өдрийн хоол идэж, наран шарлагын газар, усан спорт, Jet ski унаж, Шүхрээр буух гэх мэт сонирхолтой зүйлс хийж өнгөрүүлэх болно.



Паттаяа - Бангкок

Паттаяа хотод буудалдаа өглөөний цайгаа уусны дараа Паттаяа хотын буудлаас Бангкок хотын буудалдаа хүргүүлнэ. Орой 7:30-д Chao Phraya cruise оройн хоол иднэ. Chao Phraya cruise завин дээр та сонгодог жазз хөгжим болон 80, 90-ээд оны алдартай хөгжмийг сонсонгоо оройн хоолоо амтархан идэх болно. Cruise завин дээр тансаг оройн хоолоо идэнгээ Phra Pin-khao гүүр Wat Arun сүм, The Grand Palace, King Taksin the Great Bridge, Rama VIII Bridge гэх мэт Бангкок хотын үзэмж төгс газруудаар дамжин өнгөрөх болно. Хөтөлбөрт Cruise завиар аялах тасалбар багтсан ба хоолны зардал ороогүй болно. Та өөрт тохирсон оройн хоол, алкоголь зэргээ сонгон үйлчлүүлээрэй.



Бангкок хотын аялал

Өлөө 8 цагт буудлаас гарч Wat arun болон Нарны сүмд зочилж Тайланд үндэсний хувцас өмсөн мэргэжлийн зурагчдаар дурсгалын зургаа даруулах болно. 11:30-д завиндаа суун Tha Tien Pier, The Royal Grand Palace болон Emerald Buddha-тай танилцана. 12 цагт Wat Pho Буддын гайхамшигт сүмрүү алхан очиж Хэвтэж буй Буддаг бишрэх болно. Wat Pho сүмийг үзсэний дараа нутгийн унаа болох Tuk Tuk буюу бүхээгтэй унаанд суун цэцгийн захруу хөдлөнө. Pak Khlong Talat гэх газар очиж цэцэг нугалж сурангаа үдийн цайгаа ууна.



Бангкок-Бээжин

Буцах бэлтгэлээ ханган онгоцны буудалд хүргүүлэн Бангкок-Бээжин чиглэлийн онгоцондоо суун буцна.



Аялалд багтсан зүйлс:

- Хоёр талын онгоцны тийз
- Галт тэрэг, автобусны зардал
/Газар болон нислэг хослосон аялал
сонгосон тохиолдолд/
- 4-5 одтой зочид буудал
- Аяллын үзвэр үйлчилгээ
- Өглөөний цай
- Өдрийн хоол /хөтөлбөртэй өдөр/
- Хөтөлбөрт багтсан такси унааны зардал
- Монгол болон гадаад хөтөч

Аялалд багтаагүй зүйлс:

- Зам зуурын хоол хүнс
- Хувийн хэрэглээний зардал
- Нэмэлт тээшний зардал / хэрэв гарсан
тохиолдолд/
- Хөтөлбөрт ороогүй хөтөлбөрийг
нэмэлтээр авах
- Эрээн бээжин хот дахь хоолны зардал
- Тайланд хөтөч болон жолоочийн гарын
мөнгө тус бүр өдрийн 50 Baht
- Чөлөөт өдрийн такси унааны зардал
- Оройн хоол болон чөлөөт аяллын
өдрийн хоол